



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Сануулах шийтгэл ноогдуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дах заалт, “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3.20.2.15, 4.1.13, Хөдөлмөрийн гэрээний 3.2.4, Ёс зүйн дүрмийн 2.4, 2.5, 2.8, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.20.2.15, 4.1.13, Хөдөлмөрийн гэрээний 3.2.4, Ёс зүйн дүрмийн 2.4, 2.5, 2.8 дах заалтыг тус тус зөрчиж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй үл ойшоон хойрго хандсан, ажлын гүйцэтгэл үр дүн хангалтгүй шалтгаангүйгээр ажил тасалсан, ажлын цаг ашиглалт муу удаа дараа ёс зүйн дутагдал гаргасан тул ёс зүйн хорооны 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар бүхий хурлын дүгнэлтийг харгалзан Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн Ахлах инженер /Ц.Батдэлгэр/-т сануулах шийтгэл ноогдуулсугай.

2. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, дээрх зөрчил дутагдлыг дахин давтан гаргуулахгүй байх талаар ажил зохион байгуулж ажиллахыг Захиргаа санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга /Р.Дүүрэнбаяр/-т даалгасугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Ц.Батдэлгэрийн ажлын тайланд хяналт-шинжилгээ хийж эргүүлэн танилцуулахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /С.Халиунаа/-д даалгасугай.

ДАРГА



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

315000117